				<p>тоогоор 44 аж ахуй нэгж 109 удаа 500 горимоор бүрдүүлэлт хийж 2674.0 сая төгрөгийг түр дансанд байршуулж, 32 аж ахуй нэгж 211 удаа 300 горимоор гаалийн бүрдүүлэлт хийж 2646,4 сая төгрөгийн буцаалт олголт хийгдсэн.</p> <p>3.10 аж ахуй нэгж 420 горимоор бүрдүүлэлт хийж, гааль болон НӨАТ-ын татварт 241 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн. Төрийн сан банкин дах түр горимын дасны үлдэгдэл 540727091,85 төгрөг байсан.</p>	<p>хяналт тавьж, горимын шаардлага хангаагүй бараа байршуулаагүй байна. Түр горимд байршуулсан барааны мэдээг үнэн зөв, цаг хугацаанд нь "CERP" програмд байршуулсан байна.</p> <p>2. Нэн тааламажтай, ердийн, тарифын хөнгөлөлт эдэлж буй барааны гаалийн бүрдүүлэлтийн гарал үүслийг хянаж хууль тогтоомжийн дагуу гаалийн бүрдүүлэлтийг хийсэн байна.</p> <p>3. Татварын чөлөөлөлтөд хамрагдаж буй барааны гаалийн бүрдүүлэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэсэн байна.</p>		
--	--	--	--	---	---	--	--

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

40	Албан хаагчдын ажиллах, амьдрах орчныг сайжруулах, Хүний нөөцийн судалгаа хийж ашигласан байдал	Урсгал үйл ажиллагааны зардал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>2023 онд албан хаагчдын ажиллах амьдрах орчныг сайжруулах чиглэлээр 10 арга хэмжээг зохион байгуулж тайлагнасан.</p> <p>-Газрын дотоод хэрэгцээнд болон ГЕГ-т шаардлагатай хүний нөөцийн холбогдолтой судалгаануудыг цаг тухайд нь хийж хүргүүлж ажилласан.</p>	<p>1.2024 онд албан хаагчдын ажиллах, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр зохион байгуулах ажлыг төлөвлөж, шийдвэрлүүлж ажилласан байна.</p> <p>2.Хүний нөөцийн чиглэлийн шаардлагатай судалгааг үнэн зөв, бодитой гаргасан байна.</p>	1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал	Захиргааны алба
41	Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлд хийсэн ажил	Урсгал үйл ажиллагааны зардал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>2023 оны сургалтын төлөвлөгөө"-г албан хаагчдын гаалийн хэргийн мэдлэгийг дээшлүүлэх, гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм, сахилгыг чанд сахих, хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор боловсруулан 02 дугаар сарын 20-ны өдөр газрын даргаар батлуулан ажилласан.</p> <p>2023 оны 11 дугаар сарын 30-ны байдлаар сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 60 удаагийн 18 сургалтад</p>	<p>1.Албан хаагчдаа сургаж, чадавхжуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн төлөвлөгөө боловсруулж батлуулсан байна.</p> <p>2.Сургалтын төлөвлөгөөний биелэлт, үр дүнг тооцож, тайлагнасан байна.</p> <p>3.Хүний нөөцийн ажилтанг сургах дадлагажуулах, тогтвортой ажиллуулахад чиглэсэн тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулсан байна.</p>	1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал	Захиргааны алба

				<p>давхардсан тоогоор 1974 удирдах албан тушаалтан, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч болон албан хаагчид хамрагдсан. Сургалтыг тус гаалийн газрын алба бүр сургалтын материал хөтөлбөрийг боловсруулан нийт албан хаагчдыг идэвхтэй хамруулан зохион байгуулж ажилласан.</p> <p>Бусад байгууллагаас зохион байгуулсан 33 удаагийн сургалтад давхардсан тоогоор 795 удирдах албан тушаалтан, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч, албан хаагчид хамрагдсан.</p>			
--	--	--	--	---	--	--	--

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

42	Албан хаагчдын хувийн хэргийн баяжилт	Урсгал үйл ажиллагааны зардал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1.Тус газрын нийт 227 албан хаагчийн цаасан суурьт хувийн хэргийг 2022 оны 600 дугаар тогтоолоор Төрийн албаны зөвлөлөөс баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх” журманд нийцүүлэн бүрдүүлж, баяжилтыг хийж ажилласан.</p> <p>2.Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн нэгдсэн систем” программд, “Захиргаа дотоод ажлын систем” СЕРП программ дахь албан хаагчдын мэдээллийг цаасан суурьт хувийн хэрэгт байгаа материалтай тулгалт хийж боловсрол, ажлын туршлага, цэргийн алба хаасан, төрийн албаний ерөнхий шалгалт, тусгай шалгалт өгсөн, иргэний</p>	<p>1.Албан хаагчдын цаасан хувийн хэргийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, Гаалийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хувийн хэргийн баяжилтыг хүргүүлж ажиллана. (улирал тутам, хагас жил тутам гэх мэт, албан хаагч тус бүрээр хувийн хэргийн материалыг эмхэлж, цэгцлэн, албан бичгээр жагсаалтын хамт хүргүүлж хэвших.)</p> <p>2.Хүний нөөцийн цахим мэдээллийн санд тухай бүр баяжилт хийж, мэдээллийн үнэн зөв, бодит байдал хангагдсан байна.</p>	1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал	Захиргааны алба
----	---------------------------------------	-------------------------------	-------------------------	---	---	---	-----------------

				<p>эрүүгийн хариуцлага хүлээж байсан зэрэг мэдээллээр баяжилт хийн, нотлох баримттай тулгаж албан хаагчийн тушаал нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээллийг файлаар оруулсан.</p> <p>3.Тус гаалийн газарт Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар шилжин ирсэн, томилогдсон болон газрын даргын тушаалаар томилогдон ирсэн албан хаагчдийн хувийн хэргийг баяжуулан хүлээн авч Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн нэгдсэн систем” программд, “Захиргаа дотоод ажлын систем” СЕРП программд бүртгэн ажилласан.</p>		
--	--	--	--	--	--	--

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

43	Тушаалын хэрэгжилтийг хангаж ажилласан байдал	Урсгал үйл ажиллагааны зардал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1.Шилжин томилогдсон, шинээр байцаагчийн эрх олгогдсон, цалингийн нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, сахилгын шийтгэл ноогдуулсан болон Гаалийн ерөнхий газраас ирсэн нийт 113 Б тушаал ирсэн бөгөөд томилогдсон албан хаагчдад “Төрийн албаны тухай хууль”, “Гаалийн тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль” шинээр батлагдан мөрдөгдөж байгаа “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” болон бусад холбогдох эрх зүйн акт, тус гаалийн газрын онцлогтой холбоотой терминалд мөрдөгдөх журмыг</p>	<p>1.Албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулж Гаалийн ерөнхий газрын даргын тушаалын хэрэгжилтийг (Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу томилогдсон газарт хугацаандаа ирж ажилласан эсэх)-ийг хангаж ажилласан байна.</p>	<p>1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал</p>	Захиргааны алба
----	---	-------------------------------	-------------------------	--	--	---	-----------------

				<p>танилцуулан тушаалын хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>2. “Гаалийн улсын байцаагчид цол олгох, хураах, сэргээх, цолны нэмэгдэл хөлс олгох журам батлах тухай” А/458 тоот тушаалын журмын болзол хангасан 53 албан хаагчийн материалыг нэгтгэн, хурлын тэмдэглэлийг хавсралтаар 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 01/543 тоот албан бичгээр хүргүүлснээс 31 албан хаагчид гаалийн зөвлөх цол олгогдсон.</p>			
--	--	--	--	---	--	--	--

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

44	Цаг ашиглалт	Урсгал үйл ажиллагааны зардал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1. Жилийн эцсийн байдлаар өвчлөлийн хувьд Г.Эрдэнэбат, Б.Должинжав, Л.Хандсүрэн нарын албан хаагчдын ирцийн мэдээ ихэнх хувийг эзэлж байна. Албан хаагчид урт болон богино хугацааны лист авч байгаа тул өвчлөлийн хувь өндөр байсан.</p> <p>2. Жирэмсэн болон 0-2 насны хүүхэдтэй албан хаагчдыг шаардлагатай тохиолдолд цахимаар ажиллах нөхцөл бололцоог нь ханган ажилласан.</p> <p>3. Ээлжийн амралтын хувьд газрын даргын баталсан хуваарийн дагуу 227 албан хаагчдаас 203 албан хаагч ээлжийн амралтаа биеэр эдэлсэн.</p> <p>4. Чөлөө авалтын хувьд Чингис хаан олон улсын нисэх буудал Гаалийн газрын даргын тушаалаар цалинтай</p>	Цаг ашиглалтыг Гаалийн захиргаа, дотоод ажлын систем /CERP/-д харьяа газар, хороодын албан хаагчдын цаг ашиглалт, ээлжийн амралт, чөлөө, томилолт зэргийг тухай бүр албан хаагчид хүсэлтээ илгээсний үндсэн дээр байгууллагын удирдах ажилтан зөвшөөрөл олгосон байна.	1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал	Захиргааны алба
----	--------------	-------------------------------	-------------------------	--	--	---	-----------------

				цалингүй богино хугацааны чөлөө олгогдсон байна. Ээлжийн амралт, чөлөөний хүсэлтийг СЕРП программд тогтмол илгээж ажилласан. 5. Чингис хаан олон улсын нисэх буудлын гаалийн газрын дарга цалинтай болон цалингүй чөлөөг нотлох баримтын үндэслэн тушаал гарган олгон ажилласан.			
--	--	--	--	--	--	--	--

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

45	Гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1. CAIS системийн мэдээллийн санд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж гаалийн хяналтын төлөв тус бүрт зарцуулсан “Цаг хугацааны хэмжилт”-ийг 2 удаа хийсэн. Гаалийн хяналт, бүрдүүлэлтэд зарцуулсан цаг хугацааны хэмжилтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд бичиг баримтын шалгалт хийхэд зарцуулсан хугацаа 2.6 хувиар буурсан, биет шалгалтад зарцуулсан хугацаа 3.1 хувиар, хорио цээрийн хяналт, шалгалтад зарцуулсан хугацаа 2.3 хувиар тус тус буурч гаалийн хяналт, бүрдүүлэлтэд зарцуулсан дундаж хугацаа 2.6 хувиар буурсан байна. Гаалийн мэдүүлэг засварт буцаалт өндөр байгаа нь хяналт, бүрдүүлэлтэд зарцуулсан дундаж хугацаа буурахад нөлөөлсөн. 2. Зорчигчийн барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудас	Олон нийтэд худалдааг хөнгөвчлөх чиглэлээр мэдээлэл түгээсэн байна. Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа хийсэн байна.	1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал	Гаалийн эрсдлийн удирдлагын алба
----	---	---------------	-------------------------	---	---	---	----------------------------------

				<p>Маягт-2 хуудасны бүрдүүлэлтэд гарч байгаа алдаа цаашид анхаарах асуудал сэдвээр 3 удаагийн сургалт зохион байгуулж, үр дүнг тооцон ажилласнаар алдаа 15 хувиар буурсан.</p> <p>3. Гаалийн улсын байцаагч нарт зориулж эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тус газрын дотоод сүлжээ болон vibeg группт 10 санамж, 16 сэрэмжлүүлэг байршуулж бэлтгэж сурталчилсан.</p>		
--	--	--	--	---	--	--

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

46	Гаалийн хяналтын төлөвийн хэрэгжилт	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1.Тус газрын сүүлийн 5 жилийн бүрдүүлэлтийн мэдээлэлд төрөлжсөн судалгаа хийж, судалгаанд үндэслэн гадаад,дотоод эх үүсвэрээс эрсдэлийн мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийсний үндсэн дээр 28 аж ахуйн нэгжийн хууль сахилтын түвшиний судалгаа хийж, “Зөвшөөрөгдсөн шалгуур”, “Үл хамаарах шалгуур”, “Өндөр эрсдэлийн шалгуур”, “Заавал шалгах шалгуур”-т оруулах саналыг гаалийн эрсдэлийн удирдлагын хэлтэст хүргүүлж шийдвэрлүүлсэн. Үүний үр дүнд 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт бүрдүүлэлтийн 7.03% нь Ногоон төлөв, 24.96% нь Оранж төлөв сонгогдож, биет шалгалтаас 31.99% нь чөлөөлөгдөж, 68.01 хувь нь Улаан төлөвт</p>	<p>Гаалийн хяналтын төлөвийн дүн шинжилгээг хийж, үр дүнг тооцсон байна.</p> <p>Шалгалтын үр дүнгийн саналд дүн шинжилгээ хийж, хяналт тавьж ажиллах, үр дүнг тооцсон байна.</p>	<p>1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал</p>	Гаалийн эрсдлийн удирдлагын алба
----	-------------------------------------	---------------	-------------------------	---	--	---	----------------------------------

				<p>шалгагдсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд биет шалгалтаас чөлөөлөгдлөх хувь 10.15 хувиар өссөн.</p> <p>2. CAIS системийн мэдээллийн санд сар бүр дүн шинжилгээ хийж, “Биет шалгалтын үр дүнгийн санал”-ыг тодорхой, оновчтой, үнэн зөв оруулж байгаа эсэхэд хяналт тавьж, гаалийн улсын байцаагч нарт 2 удаа сургалт хийж, 8 удаа зөвлөмж өгч ажилласнаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд тодорхой үндэслэлтэй бичсэн саналын тоо 2.3 хувиар өссөн байна. Гаалийн хяналтын төлөв өөрчлөлтийг өнгөрсөн онтой харьцуулж үзэхэд 31.3 хувиар буурсан.</p>		
--	--	--	--	--	--	--

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

47	Гаалийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1. Тус гаалийн газрын хяналтын бүсийн орчны судалгаа, Гадаад худалдааны орчны судалгааг сүүлийн 5 жилээр хийж, гаалийн хяналт, бүрдүүлэлтийн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байгаа нь гаалийн хяналтын бүсэд гарч болох эрсдэлийг бодитойгоор тодорхойлж, гаалийн болон бусад хууль тогтоомжийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй байсан.</p> <p>2. Мэдүүлэг засварт буцаалтад хийсэн дүн шинжилгээнд үндэслэн гаалийн улсын байцаагч нарт 4 удаагийн танхимын сургалт,</p>	<p>1. Эрсдэлт бүлэгт эрсдэлийн дүн шинжилгээг хийж, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлтийг боловсруулж ГЕГ-ын эрсдэлийн удирдлага хариуцсан нэгжид хүргүүлсэн байна.</p> <p>2. Гадаад худалдаанд оролцогчдын эрсдэлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулсан байна. (ЭУСГХС 2.3 дахь хэсэг)</p> <p>3. Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтыг сайжруулах чиглэлээр сургалт, уулзалт, сурталчилгаа хийсэн байна.</p>	<p>1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал</p>	Гаалийн эрсдэлийн удирдлагын алба
----	--	---------------	-------------------------	--	---	---	-----------------------------------

				<p>бүртгэгдсэн мэргэжилтэн нарт 1 удаагийн сургалт зохион байгуулж ажилласнаар мэдүүлгийн алдаа 0.6 хувиар буурсан.</p> <p>2. “Бэлэн мөнгөний хяналт” цэсийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж гаалийн улсын байцаагч нарыг мэдээллээр хангаж ажилласнаар алдаа 50% буурсан.</p> <p>3. “Зорчигч онилох модуль” цэст дүн хийсэн дүн шинжилгээнд үндэслэн эрсдэлтэй зорчигчийн сангийн мэдээллийг тогтмол шинэчилж, гадаад, дотоод эх үүсвэрээс эрсдэлийн мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж ажилласнаар эрсдэлтэй зорчигчийн санг 128 зорчигчийн мэдээллээр баяжуулж, ач холбогдолгүй 250 зорчигчийн мэдээллийг идэвхгүй санд оруулсан.</p>			
--	--	--	--	--	--	--	--

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

48	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ажлын үр дүн	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1.Тайлант хугацаанд 3821 нислэгээр ирсэн 645173 зорчигчийн эрүүл мэндэд биеийн дулаан хэмжих төхөөрөмж, APIS системээр тандалт, зорчигчийн 967759 ш тээшинд хяналт хийж хил нэвтрүүлсэн. Гарах 3827 нислэгийн 652136 зорчигчийн эрүүл мэндэд биеийн дулаан хэмжих төхөөрөмжөөр тандалт хийж, зорчигчийн 978204 ш тээшинд хяналт тавьж ажилласан. БНХАУ хилээ нээхтэй холбогдуулан 2023</p>	<p>ДЭМБ-ын Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД-2005)-ийг хэрэгжүүлэх үндсэн чадавхын хөндлөнгийн хамтарсан үнэлгээний багаас Засгийн газарт хүргэгдсэн нэгдсэн зөвлөмжид тусгагдсаны дагуу “Нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалаар баталсан журмын үйл явдал бүрээр нарийвчлан боловсруулж, батлуулна.</p>	<p>1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал</p>	Гаалийн Хорио Цээрийн Алба
----	---	---------------	-------------------------	---	---	---	----------------------------

				<p>оны 1 дүгээр сарын 5-ны өдрөөс тус улсаас ирэх шууд 61 нислэгийн 511 нисэх бүрэлдэхүүн, 4846 зорчигч (Монгол 2378, гадаад 2468)-оос “Эрүүл мэндийн мэдүүлэг”-ийг бөглүүлэн авч, тандалт хийсэн.</p> <p>2.Хилийн нэвтрэх цэгийн бүх цагийн бэлэн байдал”-ын нийлбэр оноо 4 буюу 4-р түвшин /чадавхтай/, “Хилийн нэвтрэх цэгт хэрэгжүүлж буй нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ”- ний нийлбэр оноо 3 буюу 3-р түвшинд /чадавхжиж буй/ , “Хилийн нэвтрэх цэгт хэрэгжүүлж буй Олон улсын аялал жуулчлалтай холбоотой эрсдэлд суурилсан үнэлгээ”- ний нийлбэр оноо 2 буюу / хязгаарлагдмал чадавхтай/ нийт 3 оноо буюу 3 дугаар түвшин /чадавхжиж буй/ гэж үнэлэгдсэн.</p>			
--	--	--	--	--	--	--	--

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

49	Хилийн нэвтрэх цэг, гаалийн хяналтын бүсэд хийгдсэн халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааны үр дүн	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1.Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчин дамжин тархахаас сэргийлж, урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг ОУЭМД-ийн 22.1,2,3, 27.1-ийн а, б заалт, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Annex 9 /хавсралт 4/, Монгол улсын Сангийн сайдын 2018 оны 253 дугаар тушаал, МХЕГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/142</p>	<p>1.Халдваргүйжүүлэлтийн үр дүн, чанар, бодисын нөөцийн бүрдүүлэлт, нэр төрөл, чанарт тавих хяналтыг сайжруулна.</p> <p>2.2023 онд авагдсан судалгаан дээр үндэслэн хүрэх үр дүнгээ тодорхойлно.</p>	<p>1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал</p>	Гаалийн Хорио Цээрийн Алба
----	---	---------------	-------------------------	--	---	---	----------------------------

			<p>дугаар батлагдсан “Улсын хилийн боомт, гүний хяналтын бүсэд зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд халдваргүйжүүлэлт хийх журам”-ыг үндэслэн агаарын хөлөгт урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт гэрээний дагуу хийж ажилласан.</p> <p>2.Ирэх 1367 агаарын хөлгийн ариун цэврийн өрөөний 5345м2 талбайд халдваргүйжүүлэлт хийж, хяналт тавьж ажилласан. “Элемент” ХХК-д 8 сав хог хаягдлыг шилжүүлж, устгуулсан.</p> <p>Халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах зорилгоор хамгаалах хувцас 120 ширхэг, халат 250 ширхэг, нэг удаагийн малгай 250 ширхэг, бээлий 10200 ширхэг, N95 маск 2500 ширхэг, нэг удаагийн маск 7050 ширхэг, биологийн халдвартай хог хаягдлын 3 төрлийн уут 1850 ширхэг, санитол /1000 мл/ 55 ширхэг, санитол /300 мл/ 60 ширхэг, хөвөн 110 ширхэг, спирт 60 литр, ажлын бээлий 60 ширхэг, 2 төрлийн улавч 430 ширхэг, шингэн саван 10 ширхэг, тамедин 240 ширхэг, жавелион 2 хайрцаг, Сlоgоx 10 ширхэг, дезэфект 2 литрээр тугЕГ-ын Хуулийн хэлтэст “Олон улсын агаарын хөлөгт халдваргүйжүүлэлт хийсэн тухай” гэрчилгээний загвар, гэрээний төслийг хянуулах, баталгаажуулах, гаалийн автоматжуулсан</p>		
--	--	--	---	--	--

			удирдлагын системд хөгжүүлэлт хийлгэн халдваргүйжүүлэлтийн төлбөрийн нэхэмжлэл үүсгэх ажлыг зохион байгуулсан.			
--	--	--	--	--	--	--

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

50	Бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтыг хэрэгжүүлсэн байдал	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг зөрчсөн 27 зөрчил илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 2,700,000 төгрөгийн торгууль; Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль зөрчсөн 1 зөрчил илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн 11.22 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 100,000 төгрөгийн торгууль; Гаалийн тухай хууль зөрчих 7 зөрчлийг илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн 11.21 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг, 14 дэх хэсгийг үндэслэн 2,700,000 төгрөгийн торгууль; Тамхины хяналтын тухай хууль зөрчсөн 1 зөрчил илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг үндэслэн 300,000 төгрөгийн торгууль; Хууль бусаар галт зэвсэг эзэмших 2 зөрчил илрүүлж, хялбаршуулсан журмаар	1.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын хяналтын зөрчилтэй болон эрсдэлтэй барааг улсын хилээр нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилтыг хэрэгжүүлнэ.	1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал	Гаалийн Хорио Цээрийн Алба
----	---	---------------	-------------------------	--	--	---	----------------------------

				шийдвэрлэж 200,000 төгрөгийн торгууль ногдуулж, нийт 6,000,000 төгрөгийн торгуулийг, барагдуулсан.			
--	--	--	--	--	--	--	--

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

51	Магадлан шинжилгээний үр дүнгийн тоо, чанарын үзүүлэлт	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1.Тайлант хугацаанд гаалийн хорио цээрийн хяналтын зорилгоор 20 аж ахуйн нэгж, иргэний 16 удаагийн импорт, 5 удаагийн экспортын бараа бүтээгдэхүүнээс дээж авсан. Хорио цээрийн хяналт шалгалтын чиглэлээр нян судал, цацраг, хүнд металлын үлдэгдэл үзүүлэх зорилгоор Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторид 9, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид 12 дээж өгч шинжлүүлсэн.</p> <p>2. Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 16 өдрийн А/315 дугаар тушаалаар батлагдсан “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-ийн дагуу сорьц, дээж, загвар авах аргачлалын дагуу лабораторийн шинжилгээнд хамруулж ажилласан.</p>	7 хоног бүр хорио цээрийн лабораторийн шинжилгээний мэдээг хүргүүлнэ. Шинжилгээгээр эерэг гарсан барааг холбогдох хууль тогтоомжийн дагуу устгах, буцаах арга хэмжээг авна.	1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал	Гаалийн Хорио Цээрийн Алба
52	Экспортын гэрчилгээ, импортын мэдэгдэл, гэрчилгээний тоо, чанарт хяналт тавьж ажилласан байдал	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Тус газраас гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний махан бүтээгдэхүүнд экспортын гэрчилгээг олгож байна. Тус журмын дагуу гэрчилгээ мэдэгдлийн тооцоог сар бүр санхүүгийн албатай хийсэн.	Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах зорилт, цаг хугацаа хэмнэх, гэрчилгээ, мэдэгдлийг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай олгоно.	1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал	Гаалийн Хорио Цээрийн Алба

			<p>2. “Амьтан, ургамал, түүхий эдийн импортын гэрчилгээ” 334 ширхэг, “Мал эмнэлгийн амьд амьтан экспортын гэрчилгээ” 41 ширхэг, “Мал эмнэлгийн түүхий эд бүтээгдэхүүн экспорт гэрчилгээ” 137 ширхэг нийт 475 ширхэг (950 хос) олгож 4,750,000 төгрөгийн тэмдэгтийн хураамжийг төвлөрүүлсэн.</p> <p>3. Мал эмнэлгийн импортын хяналтаар мал, амьтны гаралтай болон далайн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн импортлодог 81 аж ахуйн нэгжийн бараанд хяналт хийж, дагалдах бичиг баримт бүрэн, тээвэрлэлтийн нөхцөл алдагдаагүй, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай, олон улсын гэрээнд заасан шаардлага, нөхцөлийг хангасан түүхий эд, бүтээгдэхүүнд 81 импортын гэрчилгээ олгосон.</p> <p>4. 41 зорчигчийн хүсэлтийн дагуу амьд мал амьтны эрүүл мэндийн 41 ширхэг гэрчилгээ, 137 иргэнээс ирүүлсэн хүсэлтээр хувийн хэрэглээний мах, махан бүтээгдэхүүнд 137 ширхэг мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ /Sanitary certificate/ олгосон.</p> <p>5. Мал эмнэлгийн экспортын хяналтаар 341 аж ахуйн нэгжийн мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлэг ариун цэврийн 341</p>		
--	--	--	---	--	--

				ширхэг гэрчилгээ баталгаажуулсан.			
Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх							
53	Хорио цээр, эрүүл ахуй, чанар, тохирлын хяналттай холбоотой бусад үйл ажиллагаа	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн дарга болон Гаалийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжаар 2023 оны 10 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Чингис хаан агаарын хилийн боомтод ДЭМБ-ын (ОУЭМД-2005)-ын үндсэн чадавхийн өөрийн үнэлгээг хийж, ажилласан. 2.Үнэлгээний урьдчилсан дүнгээр “Хилийн нэвтрэх цэгийн бүх цагийн бэлэн байдал”-ын нийлбэр оноо 3 буюу 3-р түвшин /чадавхжиж буй/, “Хилийн нэвтрэх цэгт хэрэгжүүлж буй нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ”- ний нийлбэр оноо 3 буюу 3-р түвшинд /чадавхжиж буй/ , “Хилийн нэвтрэх цэгт хэрэгжүүлж буй Олон улсын аялал жуулчлалтай холбоотой эрсдэлд суурилсан үнэлгээ”- ний нийлбэр оноо 3 буюу / чадавхжиж буй/ нийт 3 оноо буюу 3 дугаар түвшин /чадавхжиж буй/ гэж дүнтэйгээр үнэлэгдсэн. 3.Гаалийн хэргийн мэдлэг, хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын чиглэлээр мэдлэг, мэдээлэл олгох сургалтын хөтөлбөрийн хүрээнд хяналтын 7 чиглэлээр 4 ээлжийн 62 албан хаагч,	1.Хөрш зэргэлдээ улсын гаалийн газартай хийсэн санамж бичиг, протоколын хэрэгжилтийг тайлагнана. 2.Мөн сургалтыг зохион байгуулна.	1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал	Гаалийн Хорио Цээрийн Алба

				<p>нийт давхардсан тоогоор 254 албан хаагчийг 24 цагийн сургалтад хамруулсан.</p> <p>4.Хилийн хяналтын болон бусад байгууллагаас зохион байгуулсан 40 удаагийн танхимын болон цахим сургалтад давхардсан тоогоор 730 ажилтан, албан хаагчийг хамруулсан.</p>			
--	--	--	--	--	--	--	--

Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх

54	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1.Гаалийн тухай хуулийн 66.1 дэх заалтын дагуу Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хийх гаалийн бүрдүүлэлтийг гаалийн зуучлагч байгууллагаар гүйцэтгүүлж байгаа бөгөөд 13 гаалийн зуучлагч байгууллагын байнгын карго терминал дээр ажилладаг 24 ГБМ ажилладаг. Тайлант хугацаанд 811.4 сая ам.долларын үнийн дүнтэй 190,504 төрлийн бараанд 15,035 ширхэг гаалийн мэдүүлгээр гаалийн бүрдүүлэлт хийснээс 722 гаалийн мэдүүлгийг алдаанд буцаасан. Нийт 57,609 бичлэгийг 1,641 удаа буцааснаас алдааны тоонд харьцуулахад 0.86 хувийг эзэлсэн. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49.6 хувиар буурсан үзүүлэлттэй байсан.</p> <p>2.Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдийн үйл ажиллагаа, гаалийн мэдүүлгийн алдаанд тавих</p>	<p>1.Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний гаргаж байгаа алдааг бууруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулна.</p> <p>2.Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, алдааны тоо нь нийт бүрдүүлэлтийн 5 хувиас дээш гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрхийг түдгэлзүүлэх саналыг ирүүлнэ.</p> <p>3.Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний өөрийн үнэлгээний хуудсыг хагас, бүтэн жилээр Тусгай зөвшөөрлийн цахим системд дүгнэж ажиллана.</p>	<p>1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал</p>	Хяналт, бүрдүүлэлтийн алба
----	--	---------------	-------------------------	---	--	---	----------------------------

				<p>хяналтыг сайжруулах үүднээс 7 хоног бүр ГБМ тус бүрийн гаалийн бичлэгийг мэдүүлгийн буцаалтанд харьцуулах байдлаар дүг шинжилгээ хийж тухай бүр танилцуулсан. Хэрэв гаалийн бичлэг болон буцаалтын тооны харьцаа 5 хувиас дээш тохиолдол 3 ба түүнээс дээш давтагдвал гаалийн хууль тогтоомж, Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцон ажилласан.</p>			
--	--	--	--	--	--	--	--

Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх

55	<p>Гааль зөвшөөрөв төлөвөөс буцаасан мэдүүлгийг засварласан байдал, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил</p>	<p>Үйл ажиллагаа</p>	<p>Хэрэгжилт, гүйцэтгэлээр</p>	<p>1. Тус гаалийн газарт 2023.01.01-ний өдрөөс 2023.11.28-ны өдрийн байдлаар нийт 169 гаалийн мэдүүлэгт “гааль зөвшөөрөв” төлөвөөс засвар өөрчлөлт оруулсан. Үүнээс импортын 126 мэдүүлэг буюу 74.5 хувийг, экспортын 43 мэдүүлэг буюу 34.1 хувийг тус тус эзэлж байна. Нийт засварласан 169 удаагийн мэдүүлгийн алдаанаас 55 мэдүүлгийг ГЕГ-аас шалгуулахаар буцаасан, 114 мэдүүлгийг ГЕГ-т хүсэлт илгээн засварт буцаасан байна. Засварт буцаасан 169 гаалийн мэдүүлгийг тайлант хугацаан дахь нийт 16,129 гаалийн мэдүүлэгт харьцуулбал 1.07 хувь байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.3 хувиар буурсан.</p> <p>2.Гаалийн мэдүүлгийн засварт буцаалтад сар, улирал бүр</p>	<p>1.“Гааль зөвшөөрөв” төлөвөөс буцааж засварласан мэдүүлгийн нийт бүрдүүлэлтэнд эзлэх хувь өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс бууруулж ажиллана.</p> <p>2.Алдааг бууруулах чиглэлээр 3 ажил зохион байгуулна.</p> <p>3.Алдаа гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцон, анхааруулга санамж хүргүүлж ажиллана.</p>	<p>1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал</p>	<p>Хяналт, бүрдүүлэлтийн алба</p>
----	---	----------------------	--------------------------------	--	--	---	-----------------------------------

				<p>дүн шинжилгээ хийсэн ба хийсэн дүн шинжилгээнд үндэслэн ГБМ нартай 5 удаагийн хурал зохион байгуулж, олон давтамжтай алдаа гаргасан гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт 7 хоног бүр гаргасан алдаан дээр нь дүн шинжилгээ хийж, дахин алдаа гаргахгүй байх тал дээр анхааруулж ажилласан.</p> <p>3."Гааль зөвшөөрөв төлөв"-с дараах гаалийн мэдүүлгүүдийг засварт буцаан холбогдох арга хэмжээг авч ажилласан. 2023.05.26-ны өдөр 05-0713478-23-100051 дугаартай гаалийн мэдүүлсэн Чоногол трейд ХХК-ны итгэмжлэгч Ганбатын Золбоо /РД: ХГ86080510/ нь 'ГААЛЬ ЗӨВШӨӨРӨВ' төлөвөөс засварт буцаан, тээврийн баримтны тээврийн зардлыг /52,496.00 INR / дутуу мэдүүлж, 214,470.59 төгрөгний татварын зөрүү гарч татвараас зайлсхийсэн зөрчил гаргасан тул ЗТХ-ийн 11.21 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтыг үндэслэн хариуцлага тооцсон.</p>			
--	--	--	--	--	--	--	--

Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх

56	Барааны ангиллын кодтой холбоотой зохион байгуулсан ажил, мөн өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн байдал	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Тус гаалийн газарт "Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах" хүсэлт болон Гаалийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс гаалийн улсын	1.Тарифын болон тарифын бус хязгаарлалттай барааны ангиллын хяналт, шалгалтыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана. 2.Аж ахуйн нэгж, иргэд өөрөө бараагаа мэдүүлэх боломжтой болсонтой холбоотойгоор барааны ангиллын	1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал	Хяналт, бүрдүүлэлтийн алба
----	--	---------------	-------------------------	--	--	---	----------------------------

			<p>байцаагчийн шийдвэрт гаргасан гомдол байхгүй боловч бүрдүүлэлтийн явцад тус газрын барааны ангилал, үнэлгээ хариуцсан ГУБ-ийн барааны ангиллын кодод тавьсан хяналтын хүрээнд барааны ангиллын кодыг тодорхойлсон 1 шийдвэр гаргасан. Энэ нь МИАТ” ХК ийн 2023 оны 01 дугаар сарын 05-ны өдрийн 05-0210187-23-100013 сүлжээ дугаараар мэдүүлсэн АНУ-аас ирсэн Boeing767 нисэх онгоцны хөдөлгүүрийн хавхлага гэх барааны ангиллын кодыг дагалдаж ирсэн бичиг баримт дээрх 8481.10.05.10, 8807.10.00.30 ангиллын кодоос БТКУС-ийн 8807.10.00.30 гэсэн кодоор мэдүүлэх хүсэлтийг тус гаалийн газарт ирүүлсэн. Үүний дагуу мэдүүлсэн барааны нэр, тодорхойлолт онцлог шинжийг БТКУС-ийн тайлбар дүрмийн дагуу нягтлан үзээд БТКУС Зүйл 84.81-д хамаарах дүгнэлтийг гарган зохих бүрдүүлэлтийг хийсэн.</p> <p>2.Аэро Монголиа” ХХК-ийн 2023 оны 06 сарын 12-ны өдөр БНТУ-аас импортолсон “Хийлэгч, ослын гулсуурын” гэх барааг БТКУС-ийн Мөр 8807.30.00 кодод хамааруулан, 403 горимоор мэдүүлснийг бичиг баримтын бүрдүүлэлтийн явцад нягтлан шалгахад энэхүү бараа нь онгоцны ослын гулсуурыг</p>	<p>чиглэлээр зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж, ангиллын алдаа гарахаас урьдчилан сэргийлнэ.</p>		
--	--	--	---	--	--	--

			хийлэх зориулалт бүхий баллонтой “Азотын хий” байсан нь тогтоогдсон бөгөөд БТКУС-ийн мөр 2804.30.00 кодоод ангилан гаалийн бүрдүүлэлтийг хийж “Зөрчлийн тухай хууль”-ийн 11.21.15-ын дагуу “Хуульд заасан гаалийн бүрдүүлэлтийн горимын шаардлага зөрчсөн” тул 2,000,000 /хоёр сая төгрөг/-өөр торгох арга хэмжээ авч ажилласан.			
--	--	--	--	--	--	--

Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх

57	Гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойлох чиглэлээр зохион байгуулсан ажил	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1.Импортын барааны үнийн төрөлжсөн судалгаа хийн ГЕГ-ын БАҮХ-тэй танилцуулан гаалийн бүрдүүлэлтэд ашигласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Монгол Улсад бүртгэлтэй импортын 5142 орчим эм, эмийн бүтээгдэхүүнийн гаалийн үнийн судалгаа, -Алт, мөнгөн эдлэлийн үнийн судалгаа -Импортын шүр, чулууны судалгаа -Импортын амьд цэцэг, чимэглэлийн үнийн судалгаа -Гоо сайхны бараа импортлогч нэр бүхий ААН-үүдэд тээврийн тээврийн зардлын судалгаа хийсэн. -Олон давтамжтай гаалийн бүрдүүлэлт хийгддэг зарим барааны унификацийн зөвлөмж, <p>2. Импортын барааны гаалийн үнэлгээний хяналтыг сайжруулах асуудлаар ГЕГ-ын чиглэл хариуцсан газар, хэлтэст дараах саналыг</p>	<p>1.Импортын барааны хил орчмын үнийн судалгааг хийх, CAIS программын “Үнийн судалгаа” санд оруулна.</p> <p>2.Хэлцлийн үнийн санг бүрдүүлж ажиллана.</p>	<p>1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал</p>	Хяналт, бүрдүүлэлтийн алба
----	---	---------------	-------------------------	---	---	---	----------------------------

				<p>хүргүүлэн ажилласан. Импортын алт, мөнгөн эдлэлийн барааны гаалийн үнийг тодорхойлолд барааны ангилалтын хэмжээг “ширхэг” гэснийг “грамм” болгох санал; -“Бараа нийлүүлэх суурь нөхцөл” /Инкотермс2020/, “Шилжих үнэ”, “Төлбөрийн нөхцөл, төлбөр төлсөн баримт” болон хэлцлийн үнэ дээр нэмж тооцох зардалтай холбоотой асуудлаар сургалт, зөвлөмж авах талаар санал; -Агаарын тээврийн баримт (MAWB, HAWB) дээрх мэдээлэл тухайлбал, илгээгч, хүлээн авагч, дагалдаж ирсэн бичиг баримт, үнийн мэдээлэл зэргийг тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмд оруулах талаар санал;</p> <p>3. Гомдол маргаан шийдвэрлэсэн байдал: Тус гаалийн газар нь Гаалийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу гаргасан гаалийн үнэлгээтэй холбоотой 4 маргааныг шийдвэрлэсэн.</p>			
--	--	--	--	--	--	--	--

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

58	Гаалийн салбар лабораторийн үйл ажиллагаа болон лабораторийн дүгнэлтийн хэрэгжилтийг хангаж ажилласан байдал	БНХАУ-ын буцалтгүй тусламж, АХБ-ны хөнгөлөлттэй зээл, бусад хөрөнгө оруулалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1.2020 оны 4- р сарын 19- ний өдөр барилгын ажлыг эхэлж 2022 оны 10 сарын 5-нд ашиглалтад өгөхөөр гэрээ байгуулагдсан. Барилгын ажил хугацаандаа дуусаагүй тул 2 удаа гэрээ сунган ажилласан. 2.Нийт 18 нэр төрлийн барилга байгууламжийн ажлыг 12,9 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Үүнээс 9 барилга ашиглалтад орохоос 1328,7</p>	Тоног төхөөрөмжийг бүрэн худалдан авч, угсарч дуусах үйл ажиллагааг эхлүүлсэн байна.	1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал	Хяналт, бүрдүүлэлтийн алба
----	--	--	-------------------------	---	--	---	----------------------------

мкв талбай бүхий 2 давхар болон зорийн давхартай лабораторийн барилгын ажил дутуу хийгдсэн бөгөөд дутуу ажлыг хийж гүйцэтгэх асуудлаар Хилийн цэргийн 0119 дүгээр ангид албан бичгээр хандсан.

3.Байгууллагын зүгээс 2022, 2023 онд нийт 24 нэр төрлийн 1,341,955,900 нэг тэрбум гурван зуун 2023 онд 4. Гаалийн ерөнхий газарт худалдан авах ажиллагааг зохион байгуулан тус тендерт "Грийн химистри" ХХК шалгаран ГЕГ/202301005-2 дугаар гэрээ байгуулан нийт 116,818,330 /нэг зуун арван зургаан сая найман зуун арван найман мянга гурван зуун гуч/ төгрөгийн үнэ бүхий шил сав, бодис, туслах хэрэгслийг хүлээн авч холбогдох данс бүртгэлд тусгасан.дөчин нэгэн сая есөн зуун тавин таван мянга есөн зуун төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч данс бүртгэлд тусгасан.

5.2023 онд худалдан авах ажиллагааны журамд нийцүүлэн 111,008,638.00 /нэг зуун арван нэгэн сая найман мянга зургаан зуун гучин найм/ төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө, тавилга эд хогшлийн худалдан авч данс бүртгэлд тусгасан.

Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх

59	Нэгдсэн хяналтын үйл ажиллагаа	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1.Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн автоматжуулсан системд нэвтрэх эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдлыг илрүүлэх гэнэтийн шалгалт 2 удаа телехяналтын систем ашиглан гүйцэтгэсэн. Үүнд Чингис хаан олон улсын нисэх буудал хариуцсан шуурхай хяналтын өрөө болон жижүүр гаалийн улсын байцаагчийн өрөөнд байрлуулсан телехяналтын камераар шалгалт хийсэн. Уг шалгалтаар нэвтрэх эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдол гараагүй.</p> <p>2.Газрын үйл ажиллагаанд ашиглагдаж буй телехяналтын камер, компьютер, принтер, сүлжээний тоног төхөөрөмж саис, сепс, сепр, edoc системийн хэвийн ажиллагааны бүрэн бүтэн байдлыг хангаж ирсэн 27 дуудлагыг бүртгэж ажилласан. Телехяналтын системд эвдрэлтэй камер байхгүй.</p> <p>3.Телехяналтын 4 ширхэг камер шинээр суурилуулсан.</p> <p>4.Олон улсын ирэгчийн гар тээш шалгах Fiscan болон НУБИЭ ХХК-ийн Smiths detection маркийн рентген аппаратанд дүрс дамжуулах төхөөрөмж суурилуулж телехяналтын нэгдсэн системд холбосон.</p> <p>5.Явагчийн гар тээш шалгах 2 рентген аппаратанд дүрс дамжуулах төхөөрөмжийг телекамерын системд холбосон.</p>	<p>1. Телекамерийг ашиглан гаалийн хяналт, шалгалтад эрсдэл тооцож, оновчтой илрүүлсэн зөрчлийн тоо өмнөх оноос өссөн байна.</p> <p>2. Рентген апаратны хяналтын мэдээллийг дамжуулах туршилтийн ажлийг хэрэгжүүлж эхэлсэн байна.</p> <p>3. ЧХОУНБГГазрын бүх рентген төхөөрөмжид дамжуулах систем суулгахаар Шуурхай удирдлагын төвтэй хамтран ажиллаж НУБИА ХХК-ны рентген тоног төхөөрөмж, болон хилийн хяналтын байгууллагуудын дотоод хяналтын төхөөрөмжид дүрс дамжуулах судалгааг эхлүүлсэн байна.</p> <p>4.Теле хяналтын камерын угсралт суурилуулалт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайжирсан байна.</p>	1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал	Хяналт, бүрдүүлэлтийн алба, Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх алба
----	--------------------------------	---------------	-------------------------	--	---	---	--

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

60	Мэдээллийн технологийн үйл ажиллагаа	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1.Газрын үйл ажиллагаанд ашиглагдаж буй сүлжээ, програм хангамж, телехяналтын камер, компьютер, принтер, сүлжээний тоног төхөөрөмж саис, серс, серр, edoc системийн хэвийн ажиллагааны бүрэн бүтэн байдлыг ханган ажилласан.</p> <p>2.Тус гаалийн газрын ашиглаж буй компьютерт ГЕГ-аас олгосон ESET endpoint antivirus version 10.0.2045.0 суулгасан. Нийт 83 компьютер ашиглаж байгаагаас 34 компьютерт тус программыг суулгасан болно. Нийт компьютерийн 40.1 хувьд суулгасан.</p> <p>3.Хил хяналтын байгууллагуудын нэг цэгийн үйлчилгээний барилгыг Зорчигч үйлчилгээний барилгатай шилэн кабелийн холболтоор дотоод сүлжээнд холбосон. 3-4 давхарын албан ерөөнүүд, онлайн хурлын ерөөг гаалийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбосон. Хурлын ерөөнд 55 инчийн дэлгэц, cisco хурлын төхөөрөмжийг тус тус хананд тогтоож тохируулгыг хийсэн.</p> <p>4.Гаалийн хяналтын зохион байгуулалтыг сайжруулах, үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор гаалийн түр агуулахын бүртгэлийг цахимжуулах шийдлийг боловсруулж Түр агуулахын бүртгэлийн прорамыг</p>	<p>1.Байгууллагын компьютеруудад вирусны албан ёсны программ 40 хувиас доошгүй суулгасан байна.</p> <p>2.Мэдээллийн системийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, нэвтрүүлэлтийг жигдрүүлсэн байна.</p> <p>3.Мэдээллийн системийг хөгжүүлэх, боловсронгуй болгох шийдлийг судлана.</p> <p>4.Тоног төхөөрөмжийн гэмтэл саатлын дуудлага мэдээллийг бүртгэх, судалгааг хийж, бүртгэлийг хөтөлсөн байна.</p>	1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал	Захиргааны алба
----	--------------------------------------	---------------	-------------------------	---	--	--	-----------------

				нэвтрүүлж ашиглаж байна. Цаг бүртгэлийн төхөөрөмж Карго, захиргаа, буудалд суурилуулсан.			
--	--	--	--	---	--	--	--

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

61	Албаны эрэлч нохойн ашиглалт	Урсгал үйл ажиллагааны зардал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1.Тус гаалийн газар нь улирал тутам тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажилласан. Тайлант хугацаанд нийт зорчигчийн 2576 нислэгийн 406633 зорчигчийн тээшинд эрэлч нохой ашиглан гаалийн хяналт, шалгалтыг хийснээс 926 зорчигчийн тээшинд ГХША, ГХЦА болон ЗТХБА-ны ГУБ нартай хамтарсан шалгалт хийж холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэсэн.</p> <p>2.Тус сургалтын үеэр дэлхийн гаалийн байгууллагын төлөөлөгч Yeung Wong болон Америкын Нэгдсэн улсын Эрэлч нохойн нэгдсэн сургалтын төвийн дарга Keith Barker нар 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрүүдэд ГЕГ-ын дэргэдэх ЭНСТ-ийн сургалтын арга техник, сургалтын орчин, нэгдсэн сургалтад хамрагдаж байгаа гаалийн газар, хороодын эрэлч нохдын ур чадвар болоод Улаанбаатар хот болон хот орчимын гаалийн газруудад ажиллаж байгаа албаны эрэлч нохдын ажлын байран дээрхи үйл ажиллагаатай танилцсан.</p>	<p>1.Албаны эрэлч нохой ашиглан онилогдсон эрсдэлтэй зорчигчийн тээшийг нарийвчилсан үзлэгт хамруулна.</p> <p>2.Албаны эрэлч нохдын чадавхийг сайжруулах хүрээнд ЭНСТ-өөс зохион байгуулах хар тамхи болон бусад албаны эрэлч нохдыг ашиглах сургалтад хамруулна.</p> <p>3.Эрэлч нохойн амьдрах, сургах орчин нөхцөл сайжирсан байна.</p>	<p>1-р улирал, 2-р улирал, 3-р улирал, 4-р улирал</p>	Хяналт, бүрдүүлэлтийн алба
----	------------------------------	-------------------------------	-------------------------	---	---	---	----------------------------